

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

2011.03.25

Улиастай

Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал		
Гарах үр дүн: Байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод болсон байна		
Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
<p>1.1 Дараахь зүйлсийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчилж байх:</p> <ul style="list-style-type: none"> -байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн -албан хаагчийн ёс зүйн дүрэм -төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь -төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт -байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар 	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын www.zavkhan.mn вэб сайтыг ажиллуулан доорх мэдээллүүдийг олон нийтэд хүргэж байна. Аймгийн веб сайтад байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги зорилт, төлөвлөгөө, удирдлагуудын иргэдийг хүлээн авах цагийн хуваарь, хэлтсүүдийн танилцуулга мэргэжилтнүүдийн албан тушаалын эрхлэх асуудал, хаяг, утас, хөдөлмөрийн дотоод журам, зэрэг мэдээллүүдийг шинэчлэн боловсруулан байрлуулж, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээллийг цаг тухай бүр нь мэдээлж байна.</p> <p>Иргэд төрийн үйлчилгээг авахтай холбоотой материалын жагсаалт, дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан “Таны туслагч Цэнхэр ном” бизнес эрхлэх, бичил зээл тусламжид хэрхэн хамрагдах талаар болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулан гаргасан гарын авлага “Таны туслагч Шар ном”-ыг ээлж дараатай эмхэтгэн гаргаж 22000 ширхэг хэвлүүлэн өрх бүрт үнэ төлбөргүй хүргүүлсэн. Байгууллагын дотоод журам болон бусад шаардлагатай хууль тогтоомжууд, бодлогын баримт бичгүүдийг вэб хуудсанд байршууллаа.</p> <p>www.zavkhan.mn веб сайтад аймгийн Засаг даргын нийтээр дагаж мөрдөх болон хэм хэмжээ тогтоосон захирамжийг байршуулж нийтэд ил тод болгосон. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаал шийдвэрүүдийг байршуулах ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 189 дүгээр тогтоолын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газар дээр ёс зүйн хороог байгуулж, ажиллах дүрмийг батлан ажиллаж байна. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулан төрийн байгууллагуудад ёс зүйн салбар хороог байгуулан хорооны гишүүдэд 1 удаа сургалт хийгээд байна.</p>	100
1.2 Тухайн байгууллагаас үзүүлж байгаа	Иргэдэд төрийн үйлчилгээг нээлттэй, ил тод, түргэн шуурхай хүргэх үүднээс	100

<p>төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх</p>	<p>Хүний аюулгүй байдлын судалгааны төвтэй хамтран Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд “Нэг цонх”-ны үйлчилгээг 2009 оны 11 дүгээр сарын 1-ээс ажиллуулж эхлээд байна. Мөн Иргэний бүртгэлийн зөвлөгөө мэдээллийн үдийн завсарлагагүй үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна.</p> <p>Дээрх үйлчилгээгээр 60 гаруй төрлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай нэг дороос хүргэж 2010 оны дүнгээр давхардсан байдлаар 51651 иргэдэд үйлчлээд байна. “Таны туслагч Цэнхэр ном”, “Таны туслагч Шар ном”-уудыг 22000 ширхэг хэвлүүлж өрх бүрт хүргүүлээ. Уг номуудад төрийн үйлчилгээг хүртэхэд шаардлагатай мэдээлэл, бүрдүүлэх бичиг баримтууд, өрхийн аж ахуй эрхлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай гарын авлага болохуйц материалуудыг тусгаж өгсөн.</p> <p>“Төрийн цогц үйлчилгээг багт хүргэх” ажлын хэсгийг хөдөөгийн 85 багт ажиллууллаа. Энэхүү арга хэмжээний хүрээнд иргэдээс гаргасан 645 санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлээ. 2010 онд аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх “Нэг цонхны үйлчилгээ”-г сумын иргэний бүртгэл, банк, халамжийн чиглэлээр өргөжүүллээ.</p>	
<p>1.3 Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх</p>	<p>Иргэдэд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг үнэ төлбөргүй түргэн шуурхай хүргэх үүднээс Нэг цонхны үйлчилгээнд мэдээлэл зөвлөмжийн ажилтныг ажиллуулж байна. Мөн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг цахим хуудсанд байршуулан мэдээллийг тухай бүр шинэчилж байна.</p> <p>Иргэдэд хууль сурталчилах, хэрэгцээт мэдээллээр хангах үүднээс Хууль зүйн хэлтсийн дэргэд “Эрх зүйн сургалт сурталчилгааны төв” ажиллаж байна. Энэхүү төв нь иргэдэд үнэ төлбөргүйгээр хүссэн хууль, эрх зүйн зөвлөмж зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг юм.</p> <p>Нутгийн захиргааны ордонд аймгийн болон байгууллагын архив байрлаж аймгийн архивын уншлагын өрөөг шинээр нээж өгснөөр иргэдэд хэрэгцээт мэдээллийг түргэн шуурхай авч ашиглах боломжийг нээж өглөө.</p>	100
<p>1.4 Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн ямаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 324 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2002 оноос хойш батлагдсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актыг шүүж, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон 5 захирамжийг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар хүргүүлж, 2 захирамж хэм хэмжээ тогтоосон акт биш,</p>	100

<p>мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх.</p>	<p>3 захирамжийн холбогдох заалтууд хуулиар зохицуулсан харилцааг давхар зохицуулсан тухай Хууль зүй, дотоод хэргийн сайдын дүгнэлтээр 3 захирамжийн холбогдох хавсралтуудыг аймгийн Засаг даргын 2010 оны 74 дүгээр захирамжаар хүчингүй болголоо.</p> <p>Аймгийн хэмжээнд мөрдөгдөж байсан нийтээр дагаж мөрдөх 22 шийдвэрт дүн шинжилгээ хийж, ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхөө больсон, хуультай давхардсан, зөрчилдсөн, шинээр нарийвчлан зохицуулсан шийдвэр гарсан боловч хүчингүй болгоогүй захирамжуудыг хүчингүй болгож улсын нэгдсэн бүртгэлд 10 захирамж шинэчлэн бүртгүүллээ.</p> <p>Àéiãèéí Çàñàã ààðàààñ 2010 ìiä íèéòýýð ààãàæ ì°ðà°ää°ð°ð ààðààñàì “Õàèààèèòùí óèèðèùã øèíý÷èýí òìàòîî òóðàé” 52 дугаар çàðèèðàìæийг Õóóèù ç¿é, àìòîiã òýðãèéí ýàìàíã òóòèèéí òóãàòààíã хянуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүллээ.</p> <p>Нэгдсэн бүртгэлийн санд бүртгэгдэн хяналтанд авагдсан захирамжийг нийтэд мэдээллэх, хэрэгжилтэд нь 2 жил тутам хяналт, шинжилгээ үнэлгээ хийн, энэ тухай тайлан болон цаашид авах арга хэмжээний тухай саналаа Засаг даргын зөвлөл, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх тухай аймгийн Засаг даргын 2010 оны 50 дугаар захирамж гарч биелэлтийг тооцон ажиллаж байна.</p> <p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсээс улирал бүр бэлтгэн гаргадаг “Мэдээлэл” сэтгүүлийн 2010 оны 2 дугаар улирлын дугаарт аймгийн хэмжээнд мөрдөгдөж буй нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон 10 захирамжийг нэгтгэн хэвлүүлж бүх сум байгууллагуудад хүргүүллээ.</p>	
<p>1.5 Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгадаг байх</p>	<p>Аймгийн Засаг даргын шийдвэр, хэм хэмжээ тогтоосон акт гарахаас өмнө иргэд, холбогдох албан тушаалтнууд, иргэний нийгмийн байгууллагууд танилцан санал бодлоо тусгадаг байх нь эрх зүйн актын хууль зүйн үндэслэл, албан бичгийн стандартыг хангуулах, аливаа маргаан зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зэрэг чухал ач холбогдолтой тул захирамж, албан даалгавар гарахад баримтлах журам боловсруулан Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан ажиллаж байгаа нь үр дүнгээ өгч байна.</p> <p>2010 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 119 дүгээр тогтоолоор батласан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ын дагуу</p>	<p>100</p>

	шийдвэрийн төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн саналыг авч байгаа бөгөөд тус тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт, мөн ИТХ-ын шийдвэрийг бүртгэх болсонтой холбогдуулан сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарт сургалт зохион байгуулж, “Нийтээр дагаж мөрдөх шийдвэр” CD болон Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолыг бүх сумдад хүргүүлэн, хэрэгжүүлж ажиллах талаар чиглэл өгч, тус тогтоолыг хяналтанд авлаа.	
1.6 Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг/дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх	Иргэдийн санал хүсэлтийг аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, хэлтсийн дарга нар тусгай хуваарийн дагуу 7 хоног бүр хүлээн авч уулзан санал хүсэлт, өргөдлийг хүлээн авч тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Аймгийн Засаг дарга 7 хоног бүрийн Мягмар гаригт иргэдийг холбогдох хэлтэс агентлагын дарга нартай хамтран хүлээн авч уулзан асуудлыг газар дээр нь шийдвэрлэж байна. 2010 онд аймгийн хэмжээгээр нийт 8594 өргөдлийн хүлээн авч 7970 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 92,7 хувьтай байна.	100
1.7 Өргөдөл гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2009 оны 115 дугаар захирамжаар тусгай журам гарган иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэж байна.	100
Хэрэгжилтийн хувь		100
Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал		
2.1.Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлсэн байх.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын стратеги төлөвлөгөөнд байгууллагын хүний нөөцийн стратегийн чиглэлээр нэг бүлэг заалт тусган оруулж хэрэгжилтийг тооцлоо. Мөн 2010 онд аймгийн Засаг даргын Тамгын газрын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахад Хүний нөөцийн стратеги төлөвлөлтийн талаар тусгагдсан заалтын хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Мөн 2010 оны 12 дугаар сард аймгийн ЗДТГ-ын дотоод журмыг шинэчлэн боловсруулж бодлогын хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.	100
2.2.Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг	Байгууллагын стратеги төлөвлөгөөнд хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр тодорхой заалт тусган хэрэгжүүлж байна. Мөн үүнтэй холбогдуулан	100

хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусгасан байх.	байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд хүний нөөцийн ил тод байдал, ажилтан ажилд авах, чөлөөлөх талаар ил тод байдлын талаар шалгуур үзүүлэлтүүдийг хуулийн заалттай уялдуулан хэрэгжүүлж ажиллагсдын саналыг авч биелэлт, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Байгууллагад гарсан сул орон тоог нийтэд мэдээлэн төрийн албаны тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж томилж байна.	
2.3.Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлсэн байх.	Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх заалтуудыг шинэчлэхэд ажилчдын саналыг тусган гүйцэтгэлийг нь гаргахад албан хаагчдын саналыг авч мэдээллэн ажиллаж байна.	100
2.4.Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авсан байх.	Байгууллагын соёл, ил тод, нээлттэй байдлын талаар жил бүрийн 12 дугаар сарын 10-15-ны хооронд хэрэглэгчдийн үнэлгээ, албан хаагчдын саналыг авч нийтэд танилцуулдаг бөгөөд байгууллагын ил тод байдал, шударга ёсны талаар нээлттэй ярилцлага, мэдээлэл хийх ажлыг зохион байгуулж тогтмолжуулан ажиллаж байна. Төрийн албан хаагчдаас дэвшүүлсэн саналд үндэслэн албан хаагчдыг ажлын цагаар өмсөх нэг загварын оффис хувцастай болгохоор төлөвлөн ажиллаж байна. Мөн ажилчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалт, цаг ашиглалт, барилтыг хянах зэрэг ажлуудыг хийж байна.	90
2.5.Сул орон тооны зарыг нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх.	Төрийн албаны тухай хуулийн дагуу 2010 онд 6 удирдах албан тушаалтны ажлын байр, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, хэлтэс, агентлагаас 68 ажлын байрны захиалгыг орон нутгийн телевиз, сонин, Төрийн албаны зөвлөлөөр дамжуулан төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлаж томилогдох ажилтныг хууль тогтоомжийн дагуу 2 удаа төрийн албаны мэргэшлийн шалгалт зохион байгуулан сонгон шалгаруулж авсан. Төрийн жинхэнэ албаны сул орон тоог хуулийн дагуу нээлттэй ил тод өрсөлдүүлэн сонгон шалгаруулан томилж байна.	100
2.6.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байх.	Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 48 дугаар тогтоолын дагуу ажилтан албан хаагчид нь үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээгээр хүлээсэн үүрэг, ажилтаныг цаг үеийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх урамшуулах чиглэлийг удиртгал болгож байна. Албан хаагчид бүр улирал, хагас жил, сарын ажлын төлөвлөгөөтэй ажиллаж байна. 2010 онд аймгийн төрийн байгууллагуудын ерөнхий менежер, албан хаагчдыг	100

	оролцуулан гүйцэтгэл ба шударга ёс сургалтыг манлайллын сургагч багш нартай хамтран 2 үе шаттай сургалт зохион байгууллаа.	
Хэрэгжилт		98,3
Гурав. Төсөв, санхүүгийн ил тод байдал		
3.1 Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх.	Тухайн байгууллагын дараа оны төсвийн төслийг боловсруулахдаа санхүүгийн дээд шатны байгууллагын төсвийн төсөл боловсруулах удирдамжийн дагуу боловсруулж байгууллагын үйл ажиллагааны зорилго, зорилтыг үндэслэн үндсэн үйл ажиллагааг бүтээгдэхүүнээр ангилан зардлыг төлөвлөж байна.	100
3.2 Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол улсын төсвийн ил тод байдал \www.iltod.gov.mn\ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байх.	Орон нутгийн жилийн төсвийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан, батлагдсан төсвийн сар улирлын хуваарийг боловсруулж, сум харъяа нэгж байгууллагуудад хүргүүлж, аймгийн Вэб сайтад цахим хэлбэрээр байршуулж, төсвийн мэдээллийг иргэд, байгууллагад ил тод мэдээлсэн.	90
3.3 Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтанд хяналт тавих боломжийг хангасан байх.	Төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын вэб сайтад байршуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг бүрдүүлэх зорилгоор сар бүр төсвийн зарцуулалт, ашиглалтын талаарх мэдээлэл бүхий эмхэтгэлийг гаргаж байна.	90
3.4 Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх.	Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг үндэслэн хийх ажлын төлөвлөгөө гаргаж аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь www.zavkhan.mn вэб сайт болон Завхан сонинд нийтэлж нийтэд мэдээллээ.	100
3.5 Тухайн жилийн батлагдсан төсөвт	Тухайн санхүүгийн жилд төсөвт нэмэлт өөрчлөлт орж, төсөвт тодотгол хийгдсэн	100

нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр хангасан байх.	үед тухайн төсвийн өөрчлөлтийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж төсвийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг сум, харьяа нэгж байгууллагуудад танилцуулан, аймгийн вэб сайт болон орон нутгийн телевиз, радио мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тодоор мэдээлж байна.	
3.6 Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээний тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн байх.	Хууль тогтоомжид заасан байгалийн баялаг ашигласны болон тэмдэгтийн хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүнээс орсон орлогын хэмжээг сар, хагас жил, бүтэн жилээр тухай бүрд нь цахим хуудас болон товхимол хэлбэрээр гарган олон нийтэд мэдээлж байна.	100
3.7 Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх.	Төрийн үйлчилгээний байгууллагууд нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хураан авах үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамжийн хэмжээг ил тодоор байгууллагын мэдээллийн самбарт байрлуулж, түүнээс орох орлогын хэмжээг бэлэн болон бэлэн бусаар хураан авч байна. Иргэд төрийн үйлчилгээг авсан төлбөрийг банкинд очиж тушаадаг байсныг хөнгөвчилж, “Нэг цонхны үйлчилгээ”-нд банкны үйлчилгээг байршуулж иргэдийг хөнгөн шуурхай, цаг алдалгүй үйлчилгээг авахад учрах чирэгдлийг багасгалаа.	100
Хэрэгжилт		97,1
Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал		
Гарах үр дүн: Худалдан авах ажиллагаа нээлттэй ил тод болсон байна.		
4.1 Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, байгууллагын дотор мөрдөх журмыг батлан, энэ талаар олон нийтэд мэдээлсэн байх.	Худалдан авах ажиллагааны ил тод, шударга, үр ашигтай хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан бодлого баримтлан худалдан авах ажиллагааг хуулийн дагуу мөрдөн ажиллаж, орон нутгийн Завхан сонин, Завхан телевизээр олон нийтэд мэдээлэл өгсөн. Байгууллагын дотор мөрдөн ажиллах журмыг боловсрууллаа.	90
4.2 Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд	Тендерийн баримт бичиг болон журмыг хуулийн дагуу сонгон боловсруулж, урилгыг орон нутгийн www.zavkhan.mn цахим хуудсанд бололн Завхан сонинд байршуулж, жилийн батлагдсан хөрөнгө оруулалтыг Завхан сонин, Завхан телевизээр нийтэд мэдээлсэн.	100

мэдээлж, цахим хуудас \e-procurement.mn\ -т байршуулан, тогтмол шинэчилж байх	50.0 саяас дээш төсөвт өртөгтэй Нээлттэй тендер шалгаруулалтын ажил үйлчилгээг Сангийн яамны цахим хуудас /e-procurement.mn/-т байршуулсан.	
4.3 Үнэлгээний хороонд тухайн салбарын 2-оос доошгүй төрийн бус байгууллагын төлөөлөл \ашиг сонирхолын зөрчилгүй болохыг мэдэгдсэн бол\-ийг оролцуулах	Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ашиг сонирхолын зөрчилгүй болохыг мэдэгдсэн “Ногоон тэс” Төрийн бус байгууллагын төлөөллийг болон холбогдох мэргэжилтнүүдийг хамруулсан.	100
4.4 Тендерт оролцогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээлсэн байх	Тендерийн баримт бичигт тендерт оролцогчдод тавих шалгуур үзүүлэлтийг тусган шалгаруулалт явуулж, үр дүнг байгууллагын самбарт ил тод мэдээлэн тухайн байгууллагад албан тоотоор хүргүүлж байна.	100
4.5 Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулсан байх	Тендерт оролцогч байгууллагын талаарх мэдээллийг байгууллагын самбарт байрлуулан, шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийг тухайн байгууллага, аж ахуй нэгжид албан тоотоор хүргүүлж байна.	100
4.6 Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн байх	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг “худалдан авах ажиллагаа” дууссаны дараа байгууллагын цахим хуудаст байрлуулж, Сангийн яаманд улирал бүрийн эхний 2 долоо хоногт багтаан хүргүүлж байна.	100
4.7 Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх	Тендер шалгаруулалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлын талаар тухай бүр холбогдох байгууллага, аж ахуй нэгжид албан тоотоор хүргүүлсэн.	100
4.8 Худалдан авах ажиллагааны чиглэлээр холбогдох албан хаагчдыг мэргэшүүлсэн байх	2010 онд Сангийн яамнаас худалдан авах ажиллагааны талаар сургалтыг зохион явуулсан бөгөөд сургалтад худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэнг хамруулсан. Мөн уг сургалтыг орон нутагт зохион байгуулах санал тавьсны дагуу 5-р сард орон нутагт зохион байгуулж 25 хүн хамрагдсан.	100
4.9 Худалдан авах ажиллагаанд хийсэн	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад	100

аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан, түүнтэй танилцах боломжийг бүрдүүлсэн байх.	хяналт шалгалтын дүнг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан.	
4.10 Худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо, тэдгээрийн товч агуулга, шийдвэрлэсэн байдлыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт мэдээлсэн байх	Худалдан авах ажиллагааны чиглэлээр ямар нэгэн өргөдөл гомдол ирээгүй болно.	100
Хэрэгжилт		99

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.НЯМЖАВ